



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 04 өдөр

Дугаар А/01

Шивээговь сум

Онцгой комиссын бүрэлдэхүүнийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2, Засгийн газрын 2008 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 11 дугаар “Комиссын бүрэлдэхүүн, журам батлах тухай” тогтоол “Улсын онцгой комиссын ажиллах журам”-ын 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын нутаг дэвсгэрт гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах онцгой комиссыг шинэчлэн байгуулж, бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Сумын нутаг дэвсгэрт гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, гамшиг тохиолдсон нөхцөлд аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг комиссын орлогч дарга /Ч.Сугармаа/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/189 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ